

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ХУУДАС 2021-11-01

Sikaflex® -252

Тээврийн хэрэгслийн угсралтын барьцалдуулагч уян цавуу

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ (НЭМЭЛТ МЭДЭЭЛЛИЙГ ХОР АЮУЛЫН ХУУДАСНААС ҮЗНЭ ҮҮ)

Химийн суурь	1-бүрэлдэхүүнт Полиуретан
Өнгө (CQP001-1)	Хар, цагаан, саарал
Бэхжих урвал (Curing mechanism)	Чийгшилд-бэхжинэ
Нягт (бэхжээгүй үеийн)	өнгөөс хамаарна
Унжралтад тэсвэртэй байдал (Non-sag properties)	Сайн
Гүйцэтгэлийн температур	орчны
Бүрхүүл үүсэх хугацаа (CQP019-1) (Skin time)	+10 - +35 °C
Нээлттэй байх хугацаа (CQP526-1) (Open time)	40 минут ^A
Бэхжилтийн хурд (CQP049-1) (Curing speed)	35 минут ^A
Эргийн А хатуурал CQP023-1 / ISO 7619-1) (Shore A hardness)	(Диаграм 1-г үзнэ үү)
Эргийн А хатуурал CQP023-1 / ISO 7619-1) (Shore A hardness)	50
Суналтын бат бэх (CQP036-1 / ISO 527) (Tensile strength)	3 МПа
Суналтын тасралт (CQP036-1 / ISO 527) (Elongation at break)	400%
Уралтын тархалтын эсэргүүцэл (Tear propagation resistance)	7 Н/мм
Суналтын огтлолын бат бэх (CQP046-1 / ISO 4587) (Tensile lap-shear strength)	2.5 МПа
Ашиглалтын температур CQP509-1 / CQP513-1)	-40 - +90 °C
	4 цаг
	+130 °C
	1 цаг
	+150 °C
Хадгалах хугацаа (CQP016-1)	12 сар ^B

CQP = Корпорацийн Чанарын Журам (Corporate Quality Procedure)

^A +23°C / 50% харь/чийг.^B хадгалалт +25°C хэмээс доош

ТОДОРХОЙЛОЛТ

Sikaflex®-252 нь тээврийн хэрэгслийн үйлдвэрлэл дэх том хэмжээт эд ангиудыг хооронд нь холбон угсрахад ашиглах зориулан бүтээгдсэн 1-бүрэлдэхүүнт полиуретан уян цавуу юм. Энэ бүтээгдэхүүнийг хамгаалалтын түрхлэгтэй метал хийц, хуванцар болон керамик материалуудад ашиглахад тохиромжтой.

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ АШИГТАЙ БАЙДАЛ


- * Олон төрлийн гадаргуутай барьцалдах чадвар сайтай
- * Өндөр динамик даралтад тэсвэртэй
- * Нүх сүвийг дүүргэх шинж чанартай
- * Чичиргээг бууруулна
- * Цахилгаан дамжуулах-чадваргүй

ХЭРЭГЛЭХ ОРЧИН

Sikaflex®-252-г динамик даралт бүхий эд ангиудыг холбоход тохиромжтой. Мод болон метал, ялангуяа хөнгөнцагаан (жишээ нь аноджуулсан эд ангиуд), ган хайлс (үүнд фосфатжуулсан, хромжуулсан, цайрдсан г.м эд ангиуд), метал суурь түрхлэгүүд болон будгын түрхлэгүүдэд (2-бүрэлдэхүүнт), мөн керамик болон хуванцар г.м гадаргууд ашиглахад тохиромжтой. Даралтанд хагарах хандлагатай хуванцар бүтээгдэхүүнд ашиглахаасаа өмнө үйлдвэрлэгчийн зөвлөмжийг судлаарай. Энэхүү бүтээгдэхүүнийг зөвхөн мэргэжлийн туршлагатай ажилчид хэрэглэхэд тохиромжтой. Бүтээгдэхүүний бодит гадаргуутай барьцалдах болон нийцтэй байдлыг талбай дээр урьдчилан тест хийж үзэх шаардлагатай.

БЭХЖИХ УРВАЛ

Sikaflex®-252 нь агаарын чийгшилтэй урвалд орж бэхжих үйл явц явагдана. Бага температурын орчинд агаарын чийгшлийн агууламж буурдаг учир бэхжих урвал удааширдаг (Диаграм 1-ийг үзнэ үү).



Диаграм 1: Sikaflex®-252-ийн бэхжих хурд

ХИМИЙН БҮТЭЭГДЭХҮҮНД ТЭСВЭРТЭЙ БАЙДАЛ

Sikaflex®-252 нь цэвэр ус, далайн ус, шингэрүүлсэн хүчлүүд, шингэрүүлсэн идэмхий уусмалуудад тэсвэртэй; мөн түлш, эрдэс тос, ургамлын болон амьтны гаралтай өөх, тосонд богино хугацааны тэсвэртэй; харин органик хүчлүүд, гликолийн спирт, өтгөрүүлсэн эрдэс хүчлүүд ба идэмхий уусмал, уусгагч бодисуудад тэсвэргүй шинж чанартай.

АШИГЛАЛТЫН АРГАЧЛАЛ


Гадаргуун бэлтгэл

Гадаргуу нь тоос шороо, тос тосоол г.м бохирдлуудаас ангид цэвэр, хуурай байх ёстой. Барьцалтын урт удаан ашиглалтад гадаргуун боловсруулалт чухал ач холбогдолтой бөгөөд холбогч эдийн шинж чанараас хамааран хийгдэх гадаргуун боловсруулалт нь ялгаатай байна. Гадаргуун бэлтгэлийн зөвлөмжийг хамгийн сүүлийн үеийн Sika® Pretreatment – хүснэгтээс үзэх боломжтой. Энэхүү зөвлөмжүүд нь туршилт дээр үндэслэгдсэн бөгөөд бодит холбогч эдүүд дээр урьдчилан тестлэж, баталгаажуулах хэрэгтэй.

Гүйцэтгэл

Sikaflex®-252 -ийг +10 - +35 °C хэмийн температурт (орчны ба бүтээгдэхүүний) ашиглах боломжтой боловч урвалын хариу үйлдэл болон гүйцэтгэлийн шинж чанараас хамааран өөрчлөгдөх боломжтойг харгалзан авч үзэх шаардлагатай. Гадаргуун ба бүтээгдэхүүний хамгийн тохиромжтой температур нь +15 - +25 °C хооронд байна.

Бага температурт бүтээгдэхүүний зуурамтгай шинж чанар нэмэгдэхийг анхаарна уу. Гүйцэтгэлийн үед бүтээгдэхүүний ажиллагааг хялбар болгох тулд цавууг хэрэглэхээс өмнө орчны температурт тохируул. Барьцалтын шугамын зузааныг нэгэн жигд болгохын тулд цавууг гурвалжин хошуугаар түрхэхийг санал болгож байна (Зураг 1-ийг үзнэ үү).



Зураг 1: Түрхэхэд санал болгож буй хошууны тохиргоо

Sikaflex®-252 -ийг гар, хийн ба цахилгаан буу юмуу насосын төхөөрөмжүүд ашиглан түрхэж болно. Халуун, чийглэг орчинд цавууны нээлттэй хугацаа буурах учир нээлттэй байх хугацаанд тааруулан эд ангиудыг суурилуулах шаардлагатай. Цавууны гадаргуу дээр бүрхүүл үүссэн байвал эд ангийг барьцалдуулан нааж хэрхэвч болохгүй.

Өнгөлгөө

Sika® Tooling Agent N ашиглан бүтээгдэхүүний өнгөлгөөг бүрхүүл үүсэхээс хийх хэрэгтэй.

Өнгөлгөөний өөр бодис ашиглах тохиолдолд нийцтэй байдлыг урьдчилан шалгах шаардлагатай.

Цэвэрлэгээ

Sika® Remover-208 юмуу, эсвэл бусад тохиромжтой уусгагч бодис ашиглан бэхжээгүй Sikaflex®-252 -ийг багаж тоног төхөөрөмжөөс цэвэрлэнэ. Хатаж бэхжсэн бүтээгдэхүүнийг зөвхөн механик аргаар л цэвэрлэх боломжтой. Sika® Cleaner-350H гарын салфетка юмуу, эсвэл үйлдвэрлэлийн зориулалттай гарын цэвэрлэгч ашиглан гар болон биеийн ил хэсэгт наалдсан бүтээгдэхүүнийг нэн даруй цэвэрлэж авна.

Арьсанд уусгагч бодис хэрэглэж болохгүй.

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Энэхүү Бүтээгдэхүүний Үзүүлэлтийн Хуудасанд орсон мэдээллийг ерөнхий зааварчилгааны зорилгоор ашиглахыг санал болгож байна. Тусгай гүйцэтгэлийн талаарх зөвлөгөө, мэдээллийг Сикагийн Техникийн Хэлтэстэй холбогдон авах боломжтой.

Түүнчлэн дараах баримт бичгүүдийг хүсэлт гарган авах боломжтой:

*Хор Аюулыг Мэдээлэх Хуудас (SDS)

*Сикагийн 1 бүрэлдэхүүнт Полиуретан Урьдчилан Бэлтгэлийн Хүснэгт (Sika Pretreatment Chart For 1-Component Polyurethanes)

*1 бүтэлдэхүүнт Sikaflex®-ээр Чигжих ба Барьцалдуулах Гүйцэтгэлийн Ерөнхий Зөвлөмж (General Guidelines Bonding and Sealing with 1-component Sikaflex®)

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Энэхүү баримт бичигт тусгагдсан бүх техникийн үзүүлэлтүүд нь лабораторын шинжилгээний үр дүнд үндэслэгдсэн болно. Тиймээс бидний хяналтаас гадуурх нөхцөл байдлуудаас шалтгаалан бодит үзүүлэлтүүд нь ялгаатай байж болохыг анхаарна уу.

БАЙГАЛЬ ОРЧИН, ЭРҮҮЛ МЭНД БА АЮУЛГҮЙ АЖИЛЛАГАА

Бүтээгдэхүүний ашиглалт, хадгалалт болон хаягдлын талаарх мэдээлэл, зөвлөмжүүдийг тухайн бүтээгдэхүүний Аюулгүй Ажиллагааны Зааварчилгааны (ААЗ) физик, экологи, хор судлал болон аюулгүй ажиллагааны бусад мэдээллүүдээс танилцах боломжтой.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН САНАМЖ

Сикагийн бүтээгдэхүүнийг эцсийн хэрэглэгч ашиглахтай холбоотой мэдээлэл, зөвлөмжийг Сика компанид одоогоор олдсон мэдээ, мэдээлэл, туршлага дээр үндэслэн боловсруулсан бөгөөд Сика компаний зөвлөсний дагуу хэвийн нөхцөлд, зөв хадгалж, харьцаж ашигласан тохиолдолд хүчинтэй болно. Бодит амьдрал дээр хэрэглэх материал, гадаргуун байдал, ажлын байрны нөхцөлүүд ялгаатай байдаг учир дээрх мэдээллийн үндсэн дээр тухайн материал тохирох эсэхэд ямар нэгэн баталгаа гаргах боломжгүй бөгөөд зөвлөмж, зөвлөгөө өгсөнөөс үүдэн гарах эрхзүйн харилцаатай холбогдуулан бид ямар нэгэн хариуцлага хүлээхгүй болно. Хэрэглэгч тухайн бүтээгдэхүүн нь түүний хүсэж буй зорилгод нийцэж байгаа эсэхийг шалгах шаардлагатай. Сика нь өөрийн бүтээгдэхүүний шинж чанарыг өөрчлөх эрхтэй байна. Гуравдагч этгээдийн өмчийн эрхийг зөрчиж болохгүй. Одоогоор мөрдөгдөж байгаа борлуулалт, хүргэлтийн нөхцөлүүдэд нийцсэн захиалгыг хүлээн авна. Хэрэглэгч, тухайн орон нутагт ашиглагдаж буй Бүтээгдэхүүний Мэдээллийн Хуудсын сүүлийн хувилбарыг ямарт ашиглаж байх хэрэгтэй бөгөөд хүсэлтийн дагуу илгээх боломжтой болно.

Сика Монголиа ХХК
Монгол Улс,
Улаанбаатар 14200
Сүхбаатар дүүрэг-8,
Д.Сүхбаатарын талбай-2,
Сэнтрал Тауэр, 5 давхар, #504 тоот